



НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Үр дүнгийн тайлангийн хурал зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 заалт, 46 дугаар зүйлийн Сангийн сайдын 2022 оны А/282 тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, Байгууллагын үйл ажиллагааны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.8 дахь хэсэг, 2024 оны Захиргааны зөвлөлийн 11 дүгээр хурлын тэмдэглэл үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын 2024 оны төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлсэн тул байгууллага хамт олон, албан хаагчдын үр дүнгийн тайлангийн хурал, чадавхжуулах сургалтыг 2024 оны 12 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсугай.
2. Арга хэмжээний хөтөлбөрийг нэгдүгээр, арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Хавсралтаар батлагдсан 18,869,100 (арван найман сая найман зуун жаран есөн мянга нэг зуу) төгрөгийг зардлыг зөвшөөрөгдсөн нэмэлт орлогоос зарцуулахыг Ерөнхий нягтлан бодогч (Ө.Цолмон)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн ажилтан (Ч.Хишигсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Л.АРИУНТУЯА

1408010099